



АРБИТРЫН МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХЭД ШҮҮХИЙН ОРОЛЦОО

Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах
шатны шүүхийн шүүгч С.Энхбаяр

ӨМНӨТГӨЛ

Монгол Улсын Үндсэн хуулийн үзэл баримтлалтай уялдуулан нийтийн болон хувийн эрх зүйн харилцааг зохицуулсан суурь хуулиудыг шинэчлэх, шинэтгэх ажлыг бүх салбарт зохион байгуулж, улс орны хөгжлийн үндэс болсон аж ахуй эрхлэлтийг дэмжих олон талт арга хэмжээ хэрэгжүүлж ирсний нэг нь эдийн болон эдийн бус баялагтай холбоотой маргааныг шүүхийн бус журмаар шийдвэрлүүлэх институтыг сонгох чөлөөт боломжийг олгосон явдал юм.



МОНГОЛЫН
ОЛОН УЛСЫН
АРБИТР

➤ Чөлөөт зах зээлийн эдийн засгийн суурь зарчимд нийцүүлэн бизнес эрхлэн өрсөлдөх иргэн, хуулийн этгээдийн хооронд болон хуулийн этгээд хоорондын маргааныг түргэн шуурхай шийдвэрлэх хүсэл зоригийн илэрхийлэл нь арбитрын журмаар маргаан шийдвэрлэх тохиролцоо мөн.

➤ Өнөөгийн хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийн хүрээнд давж заалдах шатны шүүх арбитрын шийдвэрийг эс зөвшөөрсөн өргөдлийг хянаж, арбитрын процессын нөхөх агуулгатай хүсэлт шийдвэрлэж байгаа нь бизнес эрхлэгчдийн эрхийг хамгаалах нэг арга хэрэгсэл төдийгүй, арбитрын маргаан хянан шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлж буй харилцан уялдаа бүхий онцлог процесс юм.




Илгэлийн хүрээ: Шүүх хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцож үл болно.

1. Арбитрын маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн оролцоо
2. Арбитрын хүчин төгөлдөр шийдвэрийг хянах хүрээ хязгаар
3. Арбитрын хэлэлцээрийг шүүх шийдвэрлэж буй өнөөгийн практик, анхаарах асуудал

Иргэний
хэргийн давж
заалдах
шатны шүүх

Анхан шатны
шүүх



Арбитрын маргаанд хянан шийдвэрлэх
ажиллагааны явцад шүүхийн оролцоо

Арбитрын маргаанд хянан шийдвэрлэх ажиллагааны явцад шүүхийн оролцоо /6.2/


1. Шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах /11.1/
2. Арбитрын ажиллагаанд нэг арбитрч оролцох үед талууд арбитрчийг томилох талаар тохиролцоонд хүрээгүй бол аль нэг талын хүсэлтээр арбитрчийг шүүх... томилно./ 13.4, 13.5/
3. Арбитрчийг татгалзан гаргах хүсэлтийг шийдвэрлэх /15.3, 16.1/
4. Талууд арбитрын харьяаллын талаар маргасан асуудал. /18.7/
5. Арбитрын бүрэлдэхүүн, эсхүл түүний зөвшөөрснөөр талууд нотлох баримт гаргуулахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлтийг шүүх шийдвэрлэх /39.1/

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 160 дугаар зүйлийн 160.3-д заасан шийдвэр нь захирамж хэлбэрээр гарна

Нийслэлийн иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд

Сүүлийн 5 жилийн тоон үзүүлэлтийг судалж үзэхэд

- Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах тухай хүсэлт 35,
- Нотлох баримт гаргуулахад туслалцаа үзүүлэх тухай хүсэлт 13,
- Арбитрчийг татгалзан гаргах хүсэлт 5,
- Арбитрын харьяаллын хүсэлт 2,
- Шийдвэрийг гүйцэтгүүлэх тухай хүсэлт 2
- Арбитрын шийдвэрт гомдол гаргах хугацааг сэргээлгэх хүсэлт 17



1. Арбитраас гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулах




Иргэний шүүхэд гаргасан түр арга хэмжээ авхуулах тухай хүсэлт шийдвэрлэх ажиллагаа ба тулгамдаж буй асуудал

- Түр арга хэмжээг авхуулах хүсэлтийг шийдвэрлэсэн Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн шүүгчийн захирамжийг судалж үзэхэд Арбитрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1 дэх хэсэгт зааснаар “НОТЛОХ ҮҮРГЭЭ БИЕЛҮҮЛЭЭГҮЙ” гэх үндэслэлээр татгалзаж шийдвэрлэсэн байна.
- Түр арга хэмжээ авсан, шүүхийн практикт шүүхээс гарах шийдвэрийн биелэлтийг баталгаажуулсан тохиолдолд шийдвэр 80-аас дээш хувьтай биелдэг бөгөөд Гадаадын зарим улсын арбитрын процест түр арга авхуулах зорилго, үр дагавар, ач холбогдол зэргээс харахад нотлох шаардлага тавих нь зохимжтой эсэхэд цаашид анхаарах шаардлагатай. Учир нь түр арга хэмжээтэй холбоотой хохирлыг аль ч үед шийдвэрлэх шуурхай хуулийн зохицуулалттай бөгөөд арбитрын бүрэлдэхүүнд шийдвэрийг өөрчлөх, түдгэлзүүлэх, дуусгавар болгох зэрэг процессын эрх байгаа нөхцөлд заавал талуудаар нотлуулах шаардлагагүй.

Бусад улсын жишгийг судалж үзэхэд хэргийн бодит нөхцөл байдлыг мэдэж, маргааныг шийдвэрлэж байгаа арбитрын бүрэлдэхүүн шийдвэрлэх ба шүүх давхар шийдвэрлэх процесс оновчгүй юм

Арбитрчийг татгалзан гаргах

- ▶ Арбитрч, арбитрын бүрэлдэхүүн нь зөвхөн хараат бус, бие даасан байхаас гадна арбитрчийн ёс зүй, үнэнч шударга байдалтай шууд холбоотой бөгөөд арбитрч нь маргааныг хэргийн үйл баримт, бодит байдлыг тогтоохын тулд ямар нэгэн сэтгэлийн хөдлөл, хөндлөнгийн оролцоо, дарамт шахалтгүйгээр, аливаа хувийн сонирхолгүйгээр голч, шударгаар шийдвэрлэх үүрэгтэй.
- ▶ арбитрч нь бусдад буруу ойлголт төрүүлэхээс зайлсхийж, хэргийн оролцогч нартай тэгш хүндэтгэлтэй харилцаж, тэдэнд хэргийг шударгаар шийдвэрлэж чадна гэсэн итгэл, үнэмшлийг өөрийн үйл ажиллагаа, үг яриагаар төрүүлэж чадахуйц харилцааны соёлыг эзэмшсэн байх ёстой.
- ▶ Арбитрын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.3 дах хэсэгт “...татгалзан гаргах хүсэлтийг хангаагүй бол хүсэлт гаргасан тал шийдвэрийг хүлээн авснаас хойш олон улсын арбитрын ажиллагааны хувьд 30 хоногийн дотор, дотоодын арбитрын ажиллагааны хувьд 14 хоногийн дотор **шүүхэд гомдол гаргаж** болно. Уг гомдлыг шийдвэрлэсэн **шүүхийн шийдвэр эцсийн шийдвэр** байна...” гэж заасан.



Шүүх арбитрчийг татгалзан гаргах хүсэлт шийдвэрлэх нь хэлбэрийн төдий байх хууль зүйн боломж

Арбитрчийг
татгалзан
гаргах хүсэлт



Шүүх хүсэлтийг хангасан тохиолдолд арбитрын шийдвэр хуульд нийцэх үү

Шүүх хүсэлтийг шийдвэрлэх хүртэл хугацаанд уг арбитрч шийдвэр гаргах процесст оролцохгүй байх

Арбитрч бүрэлдэхүүнд орж, үндсэн шийдвэр гаргах боломжтой

Арбитрын шийдвэрт гомдол гаргах хугацаа



МОНГОЛЫН
ОЛОН УЛСЫН
АРБИТР

Олон улсын
арбитрын
ажиллагааны
хувьд 90 хоног

дотоодын
арбитрын
ажиллагааны
хувьд 30 хоног



Гомдол гаргах хугацаа сэргээлгэх хүсэлт

- Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хугацаа сэргээлгэх тухай хүсэлтийг Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасантай нийцэхгүй гэж хангахаас татгалзаж шийдвэрлэж байна.
- Арбитрын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт “Шүүх энэ хуульд тусгайлан зааснаас бусад тохиолдолд арбитрын ажиллагаанд оролцож үл болно.” хязгаарлалттай шууд холбоотой.
- Арбитрын тухай хуульд гомдол гаргах хугацаа сэргээх зохицуулалт байхгүй.
- Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас гомдол гаргах хугацааг хэтрүүлсэн нь баримтаар тогтоогдож байгаа тохиолдолд сэргээхгүй байх нь шударга ёсонд нийцэх үү гэх агуулгатай олон асуулт гарч ирэх юм.



Шийдвэрлэх арга зам



Арбитрын хүчин төгөлдөр
шийдвэрийг хянах хүрээ
хязгаар



Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхийн эрх хэмжээ

- Арбитрын хэлэлцээртэй маргааныг Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх хянан шийдвэрлэж байгаа нь нэг талаас хүний эрхийг хангах хэрэгсэл, нөгөө талаас нийтлэг ашиг сонирхлыг хамгаалах механизм юм.
- Арбитрын шийдвэрийг хянах хүрээ нь Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2 дах хэсэгт зааснаар хязгаарлагдах бөгөөд хууль хэрэглээ болон шийдлийг шүүх хянах эрх хэмжээ байхгүй. Өөрөөр хэлбэл, Иргэний хэргийн давж заалдах шатны шүүх нь процессыг хянаж, агуулгад орох эрх хэмжээ байхгүй.
- Арбитрын хэрэг маргаан хянан шийдвэрлэх нэг шаттай явуулах харьцангуй шуурхай процессын онцлогтой холбоотой.



а

Арбитрын хэлэлцээрийн аль нэг тал эрх зүйн чадамжгүй, эсхүл арбитрын хэлэлцээр нь талуудын тохиролцон сонгосон улсын хуульд зааснаар, эсхүл тийнхүү тохиролцон сонгоогүй бол Монгол Улсын хуульд зааснаар хүчин төгөлдөр бус

б

Өргөдөл гаргагч талд арбитрч томилох, арбитрын ажиллагааны тухай зохих ёсоор мэдэгдээгүйн улмаас арбитрын ажиллагаанд зохих ёсоор оролцох боломжгүй байсан

в

Арбитрын бүрэлдэхүүн нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй маргааны талаар үндсэн шийдвэр гаргасан. Хэрэв нэхэмжлэлийн шаардлагад тусгаагүй, хамааралгүй асуудлаар гаргасан арбитрын үндсэн шийдвэрийг нэхэмжлэлийн шаардлагад тусгасан асуудлаар гаргасан шийдвэрээс салгах боломжтой бол холбогдох хэсгийг хүчингүй болгоно

г

Талуудын тохиролцоо нь арбитрын тухай хуулийн заавал дагаж мөрдөх заалтыг зөрчсөнөөс бусад тохиолдолд арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа талуудын тохиролцоонд нийцээгүй, эсхүл тийнхүү тохиролцоогүй бол арбитрын бүрэлдэхүүн, арбитрын ажиллагаа нь энэ хуульд нийцээгүй.


а

Монгол Улсын хуулиар уг маргаан арбитрын харьяаллын маргаан биш;


б

Арбитрын үндсэн шийдвэр Монгол Улсын нийтлэг ашиг сонирхлыг зөрчсөн

Сүүлийн 5 жилийн судалгаа




НИЙСЛЭЛИЙН ИРГЭНИЙ ХЭРГИЙН ДАВЖ ЗААЛДАХ ШАТНЫ ШҮҮХ



- ХБНГУ-ын Иргэний процессын хуулийн § 1059. Хүчингүй болгуулах хүсэлт нь манай Арбитрын тухай хуулийн 47 дугаар зүйлтэй яг тохирч байгаа нь манай хөрсөнд буухгүй, эрх зүйн ухамсар сэтгэхүйн онцлогт тохироогүй хэм хэмжээг шууд хуулбарлан хэрэглэсэн нь учир дутагдалтай байна.
- Нийслэлийн Иргэний хэргийн давж заалдах шатны шүүхэд арбитрын шийдвэрийг эс зөвшөөрч гаргасан гомдлын дийлэнх нь хууль хэрэглээ, арбитрын шийдэлтэй холбоотой гомдол зонхилж байгаа бөгөөд гомдол гаргахдаа 47 дугаар зүйлийн 47.2.1а, б, в, г-ийн аль нэг үндэслэлийг иш татан, гуйвуулан тайлбарлах хэлбэрээр гаргаж байгаа нь ажиглагдав.





Арбитрын хэлэлцээрийг шүүх
шийдвэрлэж буй өнөөгийн
практик, анхаарах асуудал

Арбитрын хэлэлцээр ба харьяалал

- ▶ Арбитрын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1-д “Шүүхэд тусгайлан харьяалуулснаас бусад, арбитрын хэлэлцээрт тусгасан аливаа маргааныг арбитрын журмаар шийдвэрлэнэ.” гэж, Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2-д “Хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд заасан буюу зохигч хэлэлцэн тохиролцсон бол иргэн, хуулийн этгээдийн хооронд үүссэн маргааныг арбитр шийдвэрлэнэ.” гэж тус тус заажээ.
- ▶ Арбитрын хэлэлцээр гэж гэрээний үндсэн дээр үүссэн эсэхээс үл хамааран бий болсон эрх зүйн харилцаатай холбоотойгоор талуудын хооронд үүссэн, эсхүл үүсэж болох аливаа маргаан, эсхүл түүний тодорхой хэсгийг арбитрын журмаар шийдвэрлүүлэх тухай талуудын тохиролцоог хэлнэ.
- ▶ Гадаад улсын практикт хэрэгжүүлж, хэрэглэж буй шүүхийн бус журмаар маргаан шийдвэрлэх сонгодог аргуудад: 1. Хэлэлцээр, 2. Зуучлал, 3. Зуучийн оролцоотой хийх хэлэлцээ, 4. Хэргийн бодит байдлыг тогтоохтой холбоотой хараат бус шинжээч, 5. Омбудсмений тусламжтай маргаан шийдвэрлэх, 6. Тангарагтаны хялбаршуулсан шүүх, 7. Мини процесс, 8. Арбитрын зуучлал, Маргааны хэлэлцэх комисс зэрэг олон арга хэлбэрийг ашигладаг бөгөөд дээр шүүхийн бус арга зам нь хөгжиж байж цаашид хувийн эрх зүй хөгжих нэг хүчин зүйл болно.
- ▶ Онолын хувьд шүүх арбитрын хэлэлцээрийн талуудын эрх чөлөөний зарчмаар тохиролцож сонгосон арбитрын харьяаллыг хүндэтгэж, шийдвэрлэхгүй байх зарчимтай.

Шүүхийн практик

Арбитрын харьяаллын маргааныг шүүх шийдвэрлэхгүй

- УДШ-ийн 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн 402 дугаар тогтоолд “... Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2, 13.3-д заасныг үндэслэл болгож, мөн хуулийн 65.1.1-д зааснаар нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, 117 дугаар зүйлийн 117.1-д зааснаар хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн.”
- Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар хэрэгсэхгүй болгох агуулгатай хариу тайлбар гаргасан гэж дүгнэсэн.

Арбитрын харьяаллын маргааныг шүүх шийдвэрлэнэ

- УДШ-ийн 2018 оны 10 дугаар сарын 09-ний өдрийн 1354 дүгээр тогтоолд “...Хариуцагч талын өмгөөлөгч анхан шатны шүүх хуралдаан болох өдөр маргааныг хянан шийдвэрлэхэд баримтлах хууль болон харьяаллын талаар гаргасан хэргийг хэрэгсэхгүй болгох тухай хүсэлтийг хариуцагч талын анхны хариу тайлбар гэж, “тайлбар гаргахаасаа өмнө уг маргааныг арбитрын журмаар шийдвэрлүүлэх хүсэлт” гэж тус тус үзэх боломжгүй байна.
- Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1-д зааснаар хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа дуусгавар болох үндэслэл болохгүй.

Арбитрын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалтын агуулга

Арбитрын хэлэлцээртэй боловч шүүхэд нэхэмжлэл гаргасан

Тайлбар гаргахаасаа өмнө маргаж, харьяаллын талаар хүсэлт гаргасан

Арбитрын хэлэлцээрийн дагуу хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг дуусгавар болгоно.


Тайлбар гаргасны дараа маргасан

Арбитрын хэлэлцээрээс татгалзсан гэж үзэж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг үргэлжлүүлнэ.

Арбитрын хэлэлцээртэй маргааныг шүүх шийдвэрлэх нь талуудын зарчимд харш

- ▶ Анхан шатны шүүхэд тайлбар гаргасан эсэхээс үл хамааран хэргийг хэрэгсэхгүй болгодог тохиолдол бий.
- ▶ Арбитрын харьяаллаас маргалдагч талууд санал нэгтэй татгалзсан бол шүүх шийдвэрлэх тохиолдол байж болох юм.
- ▶ Харин, аль нэг тал нь арбитрын харьяаллын талаар маргаж байгаа тохиолдолд хариу тайлбар өмнө эсхүл хойно гэдгээр арбитрын хэлэлцээрийг шүүх шийдвэрлэх нь зохимжгүй юм.
- ▶ Олон Улсын чиг хандлага нь арбитрын хэлэлцээрийг зөвхөн арбитр шийдвэрлэх, нэг шаттай байх, талуудын гэрээний эрх чөлөө, тохиролцоог хүндэтгэх асуудлыг нэгдүгээрт тавьж байна.





Анхаарал тавьсан та
бүхэнд баярлалаа